



2024-2025

Mitsubishi Asian Children's Enikki Festa

ОРОЛЦОГЧДОД ХҮРГЭХ ЗӨВЛӨМЖ

Зохион байгуулагчид

Мицубишигийн Олон нийттэй харилцах хороо

Ази-Номхон далайн ЮНЕСКО-ийн клуб, нийгэмлэгүүдийн холбоо /AFUCA/

ЮНЕСКО-ийн клуб нийгэмлэгүүдийн Японы Үндэсний холбоо

Үндэсний хэмжээнд зохион байгуулагч

ЮНЕСКО-ийн батламжит Байгаль, соёлын өвийг хамгаалах сан

Дэмжлэг үзүүлсэн

ЮНЕСКО ()

Япон улсын Гадаад харилцааны яам

ЯПОН улсын Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яам

Оролцогч улс орнууд

Бангладеш, Бутан, Бруней, Камбож, БНХАУ, Энэтхэг, Индонез, Казакстан, БНСУ, Лаос,
Малайз, Малдив, Монгол, Мьянмар, Непал, Пакистан, Филиппин, Сингапур, Шри Ланк,
Тайвань, Тайланд, Зүүн Тимор, Вьетнам, Япон

Энэхүү зургийн уралдаан нь Азийн хүүхдүүд өдрийн тэмдэглэл /эссэ/ бүхий өөрсдийн зурсан зургаар дэлхийн өргөн олон хүүхдүүдтэй танилцах ховорхон завгааныг тэдэнд бэлэглэдэг. Бид соёлын гайхамшигт олон төрөлтэй Азийн 24 орны хүүхдүүдийг урьж буй бөгөөд тэд “Энэ миний амьдрал” чөлөөт сэдвээр өдрийн тэмдэглэл бүхий зургуудаа ирүүлэх юм. Хүүхдүүд та нар амьдралынхаа 3 өдрийг дүрслэн зурж, тус бүрт нь тэмдэглэл хийгээд өөрийн амьдралын аз жаргалтай мөчүүдээ Азийн найз, анд нөхөдтэйгөө хуваалцаарай.

1. Уралдааны үе шат

- (1) Бүтээл ирүүлэх хугацаа: 2024 оны 7 дугаар сарын 1-ээс 11 дүгээр сарын 30
- (2) Үндэсний хэмжээний шалгаруулалт: 2024 оны 12 дугаар сарын 1-31
- (3) Олон улсын шалгаруулалт: 2025 оны 4, 5 дугаар саруудад (Япон Улсад)
- (4) Япон улс дахь шагнал гардуулах ёслол болон соёлын солилцооны хөтөлбөр: 2025 оны 7 эсвэл 8 дугаар сард (Япон улсын Осака хот)

2. Оролцогчдод тавих шаардлага

(1) Бүтээлч ажил

Оролцогч хүүхэд бүрээс нийт **ГУРВАН (3)* ширхэг ЭННИКИ** (өдрийн тэмдэглэл бүхий зурсан зураг) хүлээн авна. (Зөвхөн **A-4 хэмжээтэй [297мм x 210мм] зургийн цаасан** дээр өнгийн харандаа, тосон будаг, усан будаг ашиглаж зурна.)

ЭННИКИ (Өдрийн тэмдэглэл бүхий зурсан зургууд) гэж юу вэ?

Японд өдөр тутмын үйл явдал, үзэл бодлоо зурган хэлбэрээр болон тайлбарын хамтаар илэрхийлж ЭННИКИ (өдрийн тэмдэглэл бүхий зургууд)-ийг бүтээдэг заншилтай. ЭННИКИ-г бүтээгч нь зөвхөн өөрийнхөө харсан, сонссон, бодсон зүйлүүдээ бичээд зогсохгүй бас тэдгээр үйл явдлуудаа болон мэдрэмжүүдээ зургаараа дамжуулан илэрхийлдэг. ЭННИКИ-ээр дамжуулан өөр өөр заншилтай бусад орны найз нартаа өөрийнхөө өдөр тутмын амьдралыг танилцуулахыг урьж байна. Чи өөрийнхөө амьдралын талаарх үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж болно. Оролцогчид нь зургийн тайлбар эссэгээ өөрийн төрөлх хэл дээр бичсэн байх ёстой юм.



2月15日 お寺の友だちのおうちへチボを見に行きました。チボはてんねんきねん物のずらしいワトリです。ま、白はねにくらいてんてんがおりるわてすお木をあけたり、はぎのせたりしてあそびました。こやの中には卵をあためて ちお婆さんチボがいました。てんてんがうまれたら またくるね。

2021-22 оны Фестад Япон улсаас Гран-При шагнал хүртсэн хүүхдийн зургаас.

(2) Сэдэв

“Энэ миний амьдрал” (Чи өөрийнхөө амьдралын талаарх ямар ч сэдвийг сонгож болно.)

Азийн найз нартаа мэдүүлж, ойлгуулахыг хүсэж байгаа өдөр тутмын амьдралынхаа талаар юу бодож байгаагаа “ЭННИКИ”-ээр дамжуулан илэрхийлнэ үү.

ЭННИКИ-г зурж бичихдээ өөрийн өдөр тутмын амьдрал, үйл явдал, байгаль цаг уур, дуртай тоглоом, өөрийн гэр бүл, найз нөхөд, сургуулийн амьдрал болон орон нутгийн наадам, уламжлалт урлагийн баяр зэрэг нийтлэг үйл явдлуудыг чөлөөтэй багтааж болно.

(3) Шалгаруулах үзүүлэлтүүд

Оролцох үедээ 6-12 насны байх ёстой.

Шалгаруулах хороо нь таны бүтээлийг сайн, муу гэж шүүхгүй харин өөрийн соёл, өдөр тутмын амьдралын зэрэгцээ өөрийн сэтгэгдэл, үзэл бодлоо хэрхэн яаж илэрхийлснийг түлхүү анхаарах болно.


(4) Бүтээлээ ирүүлэх хугацаа

2024 оны 6 дугаар сарын 1-ээс 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал

(5) Хэмжээ

A-4 хэмжээтэй (297мм x 210мм) зургийн цаасны дээд хэсэгт зураг (талбайн гуравны хоёрт), доод талд нь тайлбар эссэ (талбайн гуравны нэгд) байхаар байрлуулна. Эссэг 3-5 мөрөнд багтаан бичнэ.

Зураг зурсан хуудасны ар талыг цэврээр үлдээнэ.



(6) Бүтээлээ ирүүлэх явц

- Таван хуудас зураг тус бүрийнхээ ард нэрээ бичих ба 1-3 гэж (ард талд нь) дугаарлана.
- Оролцогчдод хүргэх зөвлөмжид хавсаргасан Бүртгэлийн маягт (003)-ыг бөглөөд бүтээлүүдийн хамт ирүүлнэ.
- Таны нэр зураг тус бүрийн ард бичигдсэн болон 1-3 гэж ард талд нь дугаарласан эсэхээ дахин шалгаад тэдгээр зургуудаа бүртгэлийн маягтын хамт хаягийн дагуу хүлээлгэж өгөх, эсвэл шуудангаар илгээнэ.
- Бүтээлүүдийг хооронд нь нааж цавуудах, үдээсний машинаар үдэх, ламинатардах зэргээр гэмтээж болохгүйг анхаарна уу.

(7) Шалгуур

- 1) Өргөдөл гаргагчийн бүтээл эх бүтээл байх ёстой ба хүмүүст танигдаагүй байна.

Дараах зүйлүүдэд хамаарсан тохиолдолд бүтээл хүчингүйд тооцогдоно:

- а) хэвлэгдэн гарсан ном, зургийн хуулбар
 - б) худалдааны тэмдэг буюу зохиогчийн эрхийг зөрчсөн
 - в) сонин, сэтгүүл, сурталчилгааны материалаас хуулбарласан
- 2) Бүтээлийг өргөдөл гаргагч өөрийн гараар цаасан дээр зурж, эссэг өөрөө бичсэн байх ёстой. Компьютер ашиглан бүтээсэн буюу дижитал хэлбэрээр байх ёсгүй.

(8) Шагнал

[1] Гран При (улс бүрээс нэг)

Шалгарсан хүүхдэд сертификат болон медаль гардуулна. Гран При хүртсэн хүүхэд бүр Япон Улсад уригдаж соёлын солилцооны хөтөлбөр, шагнал гардуулах ёслолд оролцож дурсгалын медаль, бэлгийг хүлээн авна. (Ямар нэгэн төлөвлөгдөөгүй саад гарсан тохиолдолд зохион байгуулагчдын шийдвэрээр аяллыг цуцлах ба оролцогчид шагналаа хүлээн авах боломжтой).

[2] Зохион байгуулагчдын шагнал

Мицубишигийн Олон нийттэй харилцах хорооны шагнал

(улс бүрээс нэг)

Сертификат болон дурсгалын бэлэг гардуулна.

Ази-Номхон далайн ЮНЕСКО-ийн клуб, нийгэмлэгүүдийн холбооны шагнал (улс бүрээс нэг)
Ялагчдад сертификат болон дурсгалын бэлэг гардуулна.

ЮНЕСКО-ийн клуб, нийгэмлэгүүдийн Японы Үндэсний холбооны шагнал (улс бүрээс нэг)

Сертификат болон дурсгалын бэлэг гардуулна.

[3] Тусгай шагнал (улс бүрээс 4)

Сертификат болон дурсгалын бэлэг гардуулна.

(9) Шалгаруулалт

Улс тус бүрийн Гүйцэтгэх хороо эхний шатны шалгаруулалтыг зохион явуулж, 8 хүүхдийн бүтээлийг сонгоно. Эдгээр 8 хүүхдийн бүтээлийг бусад орны хүүхдүүдийн бүтээлүүдтэй нэгтгэн олон улсын шалгаруулалтыг явуулна.

* Бүтээлүүдийг буцаан олгохгүй гэдгийг анхаарна уу. Бүтээлүүдийн эрх нь зохион байгуулагчид хадгалагдана.

(10) Шалгаруулах үзүүлэлт

- (1) ЭННИКИ нь соёл, ардын урлаг, нийтлэг үйл явдал, өдөр тутмын амьдрал, байгаль орчин гэх мэт улс орон, мужуудын онцлог шинжийг тусгасан эсэх
- (2) ЭННИКИ нь хүүхдийн бодит мэдрэмж, үзэл бодлыг хэрхэн тусгаж байгаа эсэх
- (3) Зохион байгуулалт, үзэл санаа, нарийн боловсруулсан байдал зэргийг бүрдүүлсэн байдал
- (4) ЭННИКИ нь өргөн хүрээтэй сэдвийг хамарсан байх

ЯМАР НЭГЭН АСУУЛТ БАЙВАЛ ДООРХ ХАЯГААР БИДЭНТЭЙ ХОЛБОГДОНО УУ:

Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р Хороо,
Нарны Зам Гудамж, “Ривер Вилла” 8/1 дүгээр байр
(Их Наяд Худалдааны Төвийн зүүн талд)
Email: enikkimongolia@gmail.com FB: fb.me/enikkifesta
Байгаль, соёлын өвийг хамгаалах сан
Харилцах утас: 99122722; 80988094

МАТЕРИАЛЫГ ДООРХ ХАЯГААР ХҮЛЭЭН АВНА:

Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р Хороо,
Нарны Зам Гудамж, “Ривер Вилла” 8/1 дүгээр байр
(Их Наяд Худалдааны Төвийн зүүн талд)
Email: enikkimongolia@gmail.com FB: fb.me/enikkifesta
Байгаль, соёлын өвийг хамгаалах сан
Харилцах утас: 99122722; 80988094